



1925

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/99

Улаанбаатар хот

Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.3 дахь заалт, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 сарын 12-ны өдрийн А/566 тоот “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай”, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 сарын 05-ны өдрийн А/112 тоот “Журам батлах тухай” тушаал, 2022 оны А/352 дугаар тушаал, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний 3 дугаар зүйлийн 3.2.7 дахь заалт, 15, 16 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам”-ыг нэгдүгээр, “Дусал, тариа хийхийн өмнө үйлчлүүлэгчийг зөв таньж тодруулах хуудас”, “Эм, өгөхийн өмнө үйлчлүүлэгчийг зөв таньж буйг үнэлэх хяналтын хуудас”, “Лабораторийн шинжилгээ хийхийн өмнө үйлчлүүлэгчийг зөв таньж буйг үнэлэх хяналтын хуудас”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

2. Батлагдсан журмын хэрэгжилтэд өдөр тутмын хяналт тавьж, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангах ажиллахыг төвийн дарга, тасгийн эрхлэгч нарт, хяналт үнэлгээ хийж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба (М.Одсүрэн)-нд үүрэг болгосугай.

3. Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бараа, материалын нийлүүлэлт зохицуулалт хийхийг Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Б.Түвшинтөр)-д, шаардлагатай төсөв хөрөнгийг тухай бүр танилцуулан шийдвэрлүүлж ажиллахыг Санхүү, бүртгэлийн алба (Н.Урансүрэн)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч (О.Баярмаа)-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ХИШИГЖАРГАЛ

000412



УЛСЫН НЭГДҮГЭЭР

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ

2024 он

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА-ҮЗТТЖ

БАТАЛГААЖИЛТ

Энэхүү журмыг боловсруулсан, хянасан, баталсан болоод хүчин төгөлдөр байдлыг дараах хүснэгтээр баталгаажуулна.

	АЛБАН ТУШААЛ	НЭР	ГАРЫН ҮСЭГ	ОГНОО
БОЛОВСРУУЛСАН	ЭМТҮЧАБА-ны дарга	М.Одсүрэн		
	ЭМТҮЧАБА-ны Эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежер	Б.Батчимэг		
ХЯНАСАН	Эмнэлзүй эрхэлсэн дэд захирлын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч	О.Баярмаа		

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА-ҮЗТТЖ

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

“Энэхүү журмыг”-ыг жилд 1-ээс доошгүй удаа хянана. Журамд тусгах шаардлагатай өөрчлөлтийг хэлэлцэж удирдлагаар баталгаажуулна.


[illegible]

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА-ҮЗТТЖ

АГУУЛГА

Д/Д	Гарчиг	Хуудас
1.	Нийтлэг үндэслэл	6
2.	Үйлчлүүлэгчийг танин тодруулах үндсэн зарчим	6-7
3.	Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчийг танин тодруулах	7
4.	Мэс засал, мэс ажилбарын үед үйлчлүүлэгчийг танин тодруулах	7-8
5.	Үйлчлүүлэгчийг таних бугуйн зүүлтийг хэрэглэх аргачлал	8-9
6.	Үйлчлүүлэгчийг таних бугуйн зүүлтийг эмнэлэг дотор хэрэглэх зохион байгуулалтын үйл явц	9-10
7.	Журмын хэрэгжилт	10-11
8.	Хяналт үнэлгээ, хариуцлага	11
9.	Холбогдох бичиг баримт	11
10.	Хяналтын хуудас	12-14

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ		
Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА-ҮЗТТЖ	



ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Эмнэлгийн тусламж үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчийг зөв танин тодруулж үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэн тусламж үйлчилгээтэй холбоотой эрсдэлийг бууруулах, тохиолдлоос сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Үйлчлүүлэгчийг танин тодруулах үндсэн зарчим

- 2.1 Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулахад хувь хүний өвөрмөц мэдээллийг ашиглана.
- 2.2 Үйлчлүүлэгчийн овог, нэр, төрсөн он сар өдөр, нас хүйсийг үйлчлүүлэгчийн өвөрмөц мэдээлэл гэнэ.
- 2.3 Үйлчлүүлэгчийн танин тодруулах үйл ажиллагаанд товч мэдээлэл бүхий бугуйн зүүлт энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасны дагуу ашиглана.
- 2.4 Үйлчлүүлэгчийг танин тодруулахдаа өвөрмөц мэдээллийг чанга тод дуугаар дуудан асууж, үйлчлүүлэгчтэй хамт дахин давтан хэлж баталгаажуулна.
- 2.5 Үйлчлүүлэгчийн танин тодруулахдаа хэвтэн эмчлүүлж буй өрөөний дугаар, орны байрлал, хувцаслалт зэргийг ашиглахгүй.
- 2.6 Тусламж үзүүлж буй эмч, сувилагч нар үйлчлүүлэгчийн бугуйн зүүлт дээрх мэдээлэлтэй тулгаж танин тодруулж тусламж үйлчилгээ үзүүлнэ.
- 2.7 Дараах тохиолдлуудад үйлчлүүлэгчийг зөв танин тодруулгыг заавал хийнэ.
 - 2.7.1 Эмчийн үзлэг хийхийн өмнө
 - 2.7.2 Шинжилгээнд сорьц авахын өмнө
 - 2.7.3 Эмийн эмчилгээний өмнө
 - 2.7.4 Дүрс оношилгоо, багажийн шинжилгээ хийхийн өмнө болон хариу хүргэх үед
 - 2.7.5 Сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэхийн өмнө

- 2.7.6 Мэс засал, мэс ажилбарын өмнө
- 2.7.7 Цус цусан бүтээгдэхүүн сэлбэхийн өмнө
- 2.7.8 Хоол сойх, эмчилгээний хоол түгээхийн өмнө
- 2.7.9 Үйлчлүүлэгч нас барсан тохиолдолд

Гурав. Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчийг танин тодруулах

- 3.1 Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчид дараах тохиолдлуудыг хамааруулна.
 - 3.1.1 Түр зуурын харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгч /ухаангүй, согтолттой, эмийн бодис их хэмжээгээр хэрэглэсэн, зохиомол амьсгалын аппараттай, эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж буй, сэрээх өрөөнд буй үйлчлүүлэгч/
 - 3.1.2 Танин мэдэхүйн алдагдалтай /тэнэгрэл, зан төрхийн өөрчлөлттэй бүхий эмгэгүүд/
 - 3.1.3 Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй үйлчлүүлэгч
 - 3.1.4 Гадаадын иргэн /орчуулагчгүй тохиолдолд/
 - 3.1.5 Нярай хүүхэд
- 3.2 Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчдийг дараах аргаар танин тодруулна.
 - 3.2.1 Үйлчлүүлэгчийн ар гэр, асран хамгаалагчаас шаардлагатай мэдээллийг авч баталгаажуулна.
 - 3.2.2 Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцахад дохионы хэлний орчуулагчаар дамжуулан танин тодруулга хийнэ.
 - 3.2.3 Хэрэв хувь хүний мэдээллийг тодруулах боломжгүй тохиолдолд цахим сүлжээнд /Ehealth/ “Овоггүй, Нэргүй” гэж тэмдэглэнэ. Регистрийн дугаарыг “ОН үсэг он сар өдөр” бичиж оруулна. (Жишээ нь: Овоггүй Нэргүй РД:ОН20220726)
 - 3.2.4 Үйлчлүүлэгчийн мэдээлэл тодорхой болсон даруйд мэдээллийг засаж бүртгэн бугуйн зүүлтийг хэрэглэнэ.

Дөрөв. Мэс засал, мэс ажилбарын үед үйлчлүүлэгчийг танин тодруулах

- 4.1 Бугуйн зүүлтийг үйлчлүүлэгчийн биеийн мэс засал хийгдэхгүй талд зүүнэ.
- 4.2 Мэс засал, мэс ажилбар хийгдэх үйлчлүүлэгчид мэдээ алдуулалт болон унтуулга хийхээс өмнө буюу мэс заслын өрөөнд орохоос өмнө танин тодруулга хийнэ.
 - 4.2.1. Үйлчлүүлэгчийн эцэг/эх/-ийн нэр, нэр
 - 4.2.2. Регистрийн дугаар
 - 4.2.3. Төрсөн он, сар, өдөр
- 4.3 Үйлчлүүлэгчийн ухаан санааны байдал хэвийн үед буюу мэдээгүйжүүлэг хийхийн өмнө үйлчлүүлэгчийн танин тодруулга хийнэ.
- 4.4 Мэс заслын хуваарьтай тулгана.
- 4.5 Мэс заслын зөвшөөрлийн хуудас, өвчний түүхийн мэдээллийг шалгана.
- 4.6 Мэс засал буюу ажилбарын өмнө явцад Time-Out буюу завсарлага хийнэ.

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА-ҮЗТТЖ

- 4.7 Мэс засал хийх эмчлэгч эмч арьсны маркер ашиглан мэс заслын талбайн тэмдэглэлийг хийнэ.
- 4.8 Хос эрхтэн, олон мөчид болон нурууны нугалмын мэс заслын үед заавал мэс заслын талбайн тэмдэглэлийг хийнэ.
- 4.9 Мэс заслын талбайд Х тэмдэг тавихыг хориглоно.
- 4.10 Мэс заслын талбайн тэмдэглэгээ нь талбайг халдваргүйжүүлж, ариун материалаар тусгаарласны дараа харагдахуйц байна.
- 4.11 Завсарлага эхлүүлэхэд мэс засал хийж буй оператор эмч үйлчлүүлэгчийн мэдээлэл, хийгдэж буй мэс засал, мэс заслын бүрэлдэхүүнийг танилцуулна.

Тав. Үйлчлүүлэгчийг таних бугуйн зүүлтийг хэрэглэх аргачлал

- 5.1 Эмнэлэг нь тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахын тулд үйлчлүүлэгчийг таних бугуйн зүүлт хэрэглэнэ.
- 5.2 Бугуйн зүүлтийг үйлчлүүлэгчийн хувь хүний онцлог, эрүүл мэндийн байдлаас шалтгаалан харгалзах өнгийн бугуйн зүүлтийг хэрэглэнэ.
- 5.3 Бугуйн зүүлт дараах үйлчлүүлэгчид хэрэглэнэ.
 - 5.3.1 Яаралтай тусламжийн тасгаар үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчид /эрэмбэ улаан, ногоон, цагаан/
 - 5.3.2 Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчид
- 5.4 Бугуйн зүүлтний өнгө нь дараах утгыг илэрхийлнэ.
 - 5.4.1 “Ягаан өнгө” эрчимт эмчилгээний тасгийн эмчлүүлэгч
 - 5.4.2 Шар өнгө” унаж бэртэх эрсдэлтэй үйлчлүүлэгч
 - 5.4.3 “Улаан өнгө” харшилтай үйлчлүүлэгч /эм тариа, хоол хүнс гэх мэт/
 - 5.4.4 “Цагаан өнгө” эрсдэлгүй үйлчлүүлэгчид
- 5.5 Бугуйн зүүлтэнд дараах мэдээлэл бичигдэнэ.
 - 5.5.1 Үйлчлүүлэгчийн овог, нэр
 - 5.5.2 Төрсөн он сар өдөр
 - 5.5.3 Нас, хүйс
 - 5.5.4 Цахим бүртгэлийн дугаар /өвчний түүхийн дугаар
 - 5.5.5 Тасаг, төвийн нэр
- 5.6 Бугуйн зүүлт зүүх, солих, авах
 - 5.6.1 Бугуйн зүүлтийг хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчид /өвчний түүх нээх хэсэгт/ бугуйн зүүлт олгоно.

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА-ҮЗТТЖ


- 5.6.2 Яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлэгчийг бугуйн зүүлтийг эрэмбийн мэргэжилтэн олгоно.
- 5.6.3 Амбулаториор үйлчлүүлэгч /**/
- 5.6.4 Бугуйн зүүлтийг насанд хүрэгчдийн зүүн гарын бугуйн хэсэгт зүүнэ.
- 5.6.5 Зүүн гарт тайрагдсан, гуурстай бол баруун гарын бугуйнд зүүнэ. Дээд мөчид зүүх боломжгүй тохиолдолд зүүн хөлийн шилбэнд зүүнэ.
- 5.6.6 Бугуйн зүүлтийн мэдээлэл арилсан, буруу бичигдсэн, бугуйвч гээгдсэн тохиолдолд нэн даруй сольж үйлчлүүлэгчийн мэдээллийг тулган дахин бугуйн зүүлт олгоно.
- 5.6.7 Бугуйн зүүлтийг тусламж үйлчилгээ үзүүлж буй тасгийн сувилагч үйлчлүүлэгчийн биеийн байдалд тохируулан бугуйн зүүлтний өнгийг өөрчлөх, нэмж зүүлгэж хэрэглэнэ.
- 5.6.8 Бугуйн зүүлтийг эмнэлгээс гарах, эмнэлэг хооронд шилжүүлэх үед үйлчлүүлэгчийн бугуйн зүүлтийг авна.
- 5.6.9 Үйлчлүүлэгч нас барсан тохиолдолд бугуйн зүүлт дээрх мэдээллийг нягтлан, бугуйн зүүлтийг тайлалгүй зан үйлийн өрөө рүү тээвэрлэнэ.

Зургаа. Үйлчлүүлэгчийг таних бугуйн зүүлтийг эмнэлэг дотор хэрэглэх зохион байгуулалтын үйл явц

- 6.1 Үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлүүлэх захиалгад бүртгэж буй амбулаториор болон яаралтай тусламжийн хэсэгт үзлэг хийсэн эмч үйлчлүүлэгчийн эрсдэлийг үнэлэн бугуйн зүүлтний өнгийг хэвтүүлэх захиалгын хуудаст сонгоно.
- 6.2 Өвчний түүх нээх хэсэгт хэвтүүлэх захиалгад бүртгэсэн эмчийн бүртгэлийн дагуу өвчний түүх нээхэд үйлчлүүлэгчийн зүүх бугуйвч хэвлэгдэж үйлчлүүлэгчид хүлээлгэн өгнө.
- 6.3 Үйлчлүүлэгчийн бугуйвч дээр тус журмын 5.5 дугаар зүйлд заагдсан мэдээлэл хэвлэгдсэн байна.
- 6.4. Үйлчлүүлэгчийг зөв таних эмнэлэг доторх үйл явц дараах процессын зураглалын дагуу явагдана /Зураг 1/

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА-ҮЗТТЖ

Зураг 1. Үйлчлүүлэгчийг зөв танин, тодруулах урсгал процесс



Долоо. Журмын хэрэгжилт

- 7.1 Үйлчлүүлэгчийг зөв таних үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалтыг Эмнэлзүйн алба хариуцаж ажиллана.
- 7.2 Тасаг төвийн чанарын багийн гишүүд сар бүр хэрэгжилтэнд хяналт тавьж Сувилахуйн алба, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанд мэдээлэн Эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежер улирал бүр дүгнэлт үнэлгээ хийнэ.

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА-ҮЗТТЖ

7.3 Жилийн эцсийн дүгнэлтийг эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежер нь байгууллагын удирдлагын багт тайлагнана

7.4. Журамд оруулсан өөрчлөлтийг өөрчлөлтийн бүртгэлд тэмдэглэнэ

Найм. Хяналт үнэлгээ, хариуцлага

8.1. Уг журмын хэрэгжилтэд Сувилахуйн алба, ЭМТҮЧАБАлба хяналт тавина.

8.2. Дээрх дурдсанаас гадна журамд тухайн цаг үеийн онцлог болон хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулж болно.

8.3 Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журмыг баримтлаагүй тохиолдолд эрүүл мэндийн захиргааны байгууллагаас баталсан журмын дагуу мэдээлэх хуудас бөглөн Эрүүл мэндийн чанар аюулгүй байдлын албанд мэдээлнэ.

Ес. Холбогдох бичиг баримт

9.1 Монгол Улсын хууль тогтоомж

9.2. Монгол Улсын стандарт “Чанарын менежментийн тогтолцоо- Шаардлага ISO 9001:2015 стандарт”

9.3 УНТЭ-ийн 2022 оны А/135 тоот “Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ” тушаал

9.4 Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 сарын 12-ны өдрийн А/566 тоот “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” тушаал.

9.5 ЭМС-ийн 2024 оны А/112 тоот “Журам батлах тухай” тушаал


9.6 ЭМС-ын 2022 оны А/352 тоот “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам” тушаал

9.7 Бусад журам, дүрэм заавар

----- 000000 -----

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА-ҮЗТТЖ

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн А/99 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Дусал, тариа хийхийн өмнө үйлчлүүлэгчийг зөв таньж буйг үнэлэх хяналтын хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм/Үгүй	Нэмэлт мэдээлэл
1	Эмч, сувилагч үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах арга хэрэглэж байна уу?		
2	Зөв таних 2 аргыг хэрэглэж байна уу?		
3	Үйлчлүүлэгчид харшилтай эм тариа байдаг эсэхийг тодруулж байна уу?		
4	Эмчийн бичсэн тарилгын нэр, тун хэмжээтэй тохирч буйг нягталж байна уу?		
5	Тарилгыг хэрэглэх арга, найруулах уусмал, түүний хүчинтэй хугацаа зэргийг нягталж байна уу?		
6	Үйлчлүүлэгчид хэрэглэх гэж буй тарилгын нэр, хүчинтэй хугацааг тайлбарлаж байна уу?		
7	Анхан шатны бүртгэл мэдээлд тэмдэглэгээ хийхдээ зөв таних аргыг хэрэглэж байна уу?		
8	Эрсдэлтэй үйлчлүүлэгчид тохирох өнгийн зүүлт/бугуйвч зүүлгэсэн үү?		
9	Үйлчлүүлэгчид зүүлт/бугуйвч зүүлгэх талаар тайлбарлаж байна уу?		
10	Зүүлт/бугуйвч зүүлгэсэн тухай өвчний түүхэнд тэмдэглэж байна уу?		
11	Зүүлт/ бугуйвчинд байх мэдээллийг бүрэн оруулсан уу?		
12	Эмнэлгээс гарахаас өмнө зүүлт/ бугуйвчийг авсан уу?		
	Нийт оноо 12		

Тайлбар: **Тийм** бол 1 оноо, **Үгүй** бол 0 оноо, **Хамаарахгүй** бол X

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА-ҮЗТТЖ

**Эм өгөхийн өмнө үйлчлүүлэгчийг зөв таньж буйг үнэлэх
хяналтын хуудас**

№	Шалгуур үзүүлэлт	Тийм/Үгүй	Нэмэлт мэдээлэл
1	Эмч, сувилагч үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах арга хэрэглэж байна уу?		
2	Зөв таних 2 аргыг хэрэглэж байна уу?		
3	Үйлчлүүлэгчид харшилтай эм байдаг эсэхийг тодруулж байна уу?		
4	Эмчийн бичсэн эмийн нэр, тун хэмжээтэй тохирч буйг нягталж байна уу?		
5	Эмийн хүчинтэй хугацаа зэргийг нягталж байна уу?		
6	Үйлчлүүлэгчид өгөх гэж буй эмийн нэр, уух аргыг тайлбарлаж байна уу?		
7	Анхан шатны бүртгэл мэдээлд тэмдэглэгээ хийхдээ зөв таних аргыг хэрэглэж байна уу?		
8	Эрсдэлтэй үйлчлүүлэгчид тохирох өнгийн зүүлт/бугуйвч зүүлгэсэн үү?		
9	Үйлчлүүлэгчид зүүлт/бугуйвч зүүлгэх талаар тайлбарлаж байна уу?		
10	Зүүлт/бугуйвч зүүлгэсэн тухай өвчний түүхэнд тэмдэглэж байна уу?		
11	Зүүлт/ бугуйвчинд байх мэдээллийг бүрэн оруулсан уу?		
12	Эмнэлгээс гарахаас өмнө зүүлт/ бугуйвчийг авсан уу?		
	Нийт оноо 12		

Тайлбар: **Тийм** бол 1 оноо, **Үгүй** бол 0 оноо, **Хамаарахгүй** бол X

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА-ҮЗТТЖ

**Лабораторийн шинжилгээ хийхийн өмнө үйлчлүүлэгчийг зөв таньж буйг
үнэлэх хяналтын хуудас**

№	Шалгуур үзүүлэлт	Тийм/Үгүй	Нэмэлт мэдээлэл
1	Шинжилгээ авахын өмнө үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах арга хэрэглэж байна уу?		
2	Зөв таних 2 аргыг хэрэглэж байна уу ?		
3	Сорьц авахын өмнө эмчийн бичсэн шинжилгээний заалттай тохирч буйг нягталж байна уу		
4	Шинжилгээ авахын өмнө үйлчлүүлэгчээс урьд өдөр хоол, хүнсний дэглэм, хэрэглээний талаар, шээсний шинжилгээг өгч буй бол зөв шээсийг цуглуулсан талаар тодруулж, зөв сорьц авч буйд дүгнэлт хийж байна уу?		
5	Үйлчлүүлэгчээс шинжилгээ авахын өмнө ажилбарын талаар анхааруулж, мэдэгдэж байна уу?		
6	Сорьцтой хуруу шил, сав дээр шошгыг заавал үйлчлүүлэгчийн дэргэд нааж байна уу?		
7	Шинжилгээний явц бүрт шинжилгээг зөв таних арга хэрэглэж, нягталж байна уу?		
8	Анхан шатны бүртгэл мэдээлд тэмдэглэгээ хийхдээ зөв таних аргыг хэрэглэж байна уу?		
9	Эрсдэлтэй үйлчлүүлэгчид тохирох өнгийн зүүлт/бугуйвч зүүлгэсэн үү?		
10	Үйлчлүүлэгчид зүүлт/бугуйвч зүүлгэх талаар тайлбарлаж байна уу?		
11	Зүүлт/бугуйвч зүүлгэсэн тухай өвчний түүхэнд тэмдэглэж байна уу?		
12	Зүүлт/ бугуйвчинд байх мэдээллийг бүрэн оруулсан уу?		
13	Эмнэлгээс гарахаас өмнө зүүлт/ бугуйвчийг авсан уу?		
	Нийт оноо 13		

Тайлбар: **Тийм** бол 1 оноо, **Үгүй** бол 0 оноо, **Хамаарахгүй** бол X